

Vendor Relationship системийн хэрэглээний гарын авлага



Vendorship

Анхны хувилбар

2025

Эрхэм хүндэт харилцагч танд энэ өдрийн мэндийг хүргэе.

“Премиум Нэксус” ХК-ийн зүгээс манай байгууллагатай хамтран ажиллаж буй, мөн цаашид хамтын ажиллагаагаа хөгжүүлэх сонирхолтой нийлүүлэгч байгууллага, эрх бүхий төлөөлөгч танд зориулан энэхүү Vendor Relationship System (VRS) системийн хэрэглээний гарын авлагыг боловсруулан хүргэж байна.

Энэхүү гарын авлага нь VRS системийг ашиглан худалдан авалттай холбоотой үйл ажиллагаанд хэрхэн оролцох, мэдээлэл илгээх, хянах болон баталгаажуулах зэрэг гол функцуудыг хэрхэн ашиглах талаар алхам алхмаар тайлбарласан болно. Системийн гарын авлагыг анхлан ашигласдад ойлгомжтой байлгах үүднээс дэлгэцийн зураг, жишээ мэдээллүүдээр баяжуулан, практик хэрэглээнд тулгуурлан бүтээсэн.

Vendor Relationship System нь “Премиум Нэксус” ХК-ийн нийлүүлэгчидтэй харилцах, хамтын ажиллагааг илүү үр дүнтэй, нээлттэй, цахим орчинд явуулахад зориулагдсан нэгдсэн систем юм. Энэхүү системийг ашигласнаар танд дараах боломжууд нээгдэх болно:

- Мэдээлэл шуурхай солилцох
- Бүтээгдэхүүний захиалга хянах
- Баримт бичиг илгээх, баталгаажуулах
- Шинэ боломжуудын талаарх мэдэгдэл хүлээн авах
- Бүтээгдэхүүнтэй холбоотой бүхий л төрлийн хүсэлтийг өгөх

Бид энэхүү системийг ашиглан харилцан итгэлцэлтэй, ил тод, шуурхай хамтын ажиллагааг бий болгоход анхаарч ажиллаж байна. Та энэхүү гарын авлагыг ашигласнаар VRS системийг илүү үр дүнтэй ашиглаж, хамтын ажиллагааг шинэ түвшинд хүргэх бүрэн боломжтой.


Хүндэтгэсэн,

“Премиум Нэксус” ХК




1. Шинээр нийлүүлэгч болох


Та систем рүү өөрийн болон өөрийн төлөөлж буй байгууллагын регистрийн дугаараар бүртгэл үүсгэн орно. Мөн та өөрийн болон өөрийн төлөөлж буй байгууллагын бүртгэлээ бүрэн оруулсан тохиолдолд манай системийг ашиглах эрх үүсэх ба бусад тохиолдолд системийн цонхнууд үйлдэл хийх боломжгүй буюу цоожтой байна.



2. Нүүр



3. Хянах самбар



4. Хүсэлтүүд

Энэхүү цэсээр та бүтээгдэхүүн болон хамтын ажиллагаатай холбоотой бүхий л хүсэлтийг өгөх буюу түүний тухайн цагийн төлөвийн мэдээллийг харах боломжтой.

1. Шинэ


бүтээгдэхүүн

Таны болон
таны төлөөлж
буй

байгууллагын

санал болгож

буй шинэ бүтээгдэхүүнийг CU ая тухтай сүлжээ дэлгүүрт танилцуулж, системээр дамжуулан илгээх хэсэг.




- **Хадгалсан** - Таны хараахан илгээгээгүй байгаа хүсэлтүүд буюу хувийн draft хэсэг
- **Илгээсэн** - Амжилттай илгээсэн хүсэлтүүд
- **Шийдвэрлэгдсэн** - Шийдвэрлэгдэж дууссан хүсэлтүүд
- **Шинэ хүсэлт** – Шинээр бүтээгдэхүүн нэвтрүүлэх хүсэлт илгээх
- **Файл хуулах** – Загварын дагуу нэг дор олон бүтээгдэхүүн хуулах хэсэг
- **Багана тохиргоо** – Та хураангуй хэсгээс өөрийн шууд харахыг хүсэж буй багануудын тохиргоог өөрийн ажлын арга барилд тохируулж өөрчлөх боломжтой

?



Миний хүсэлт илгээсэн бүтээгдэхүүн хэдий хугацаанд шийдвэрлэгдэх вэ?

-Таны хүсэлт бүрийн ард Төлөв гэх хэсэг байрлах ба та түүн дээр товшиж өөрийн хүсэлтийн процесс аль шатанд явж байгаа тухай мэдээллийг авах боломжтой.



2. Үнийн хүсэлт

Энэхүү цэс нь одоогоор нийлүүлж буй бүтээгдэхүүнд үнэ өөрчлөх санал гаргах үед ашиглана.



- **Хадгалсан** - Таны хараахан илгээгээгүй байгаа хүсэлтүүд буюу хувийн draft хэсэг
- **Шийдвэрлэгдсэн** - Шийдвэрлэгдэж дууссан хүсэлтүүд
- **Шинэ хүсэлт** - Шинээр бүтээгдэхүүний үнэ өөрчлөх хүсэлт илгээх



- **Багана тохиргоо** – Та хураангуй хэсгээс өөрийн шууд харахыг хүсэж буй багануудын тохиргоог өөрийн ажлын арга барилд тохируулж өөрчлөх боломжтой

Бүтээгдэхүүний үнийг өөрчлөх санал илгээх гэсэн боловч зөвхөн 1 болон 15-ны өдрүүд л нээлттэй байна. Системийн алдаа гарсан уу?

-Харамсалтай нь үгүй. Бид ая тухтай сүлжээний хэмжээнд сардаа хоёр удаа буюу сар бүрийн 1 болон 15-ны өдрүүдэд бүтээгдэхүүний үнийг өөрчилдөг тул тухайн заагдсан өдрүүдээс сонгох шаардлагатай.

3. Урамшуулал

Нийлүүлж буй
бүтээгдэхүүнд
хамаарах
хямдрал,
урамшуулал,
сугалааны

нөхцөл хугацаа зэргийг мэдээлэх цэс. Урамшууллын мэдээлэл нь баталгаажсаны дараа CU ая тухтай дэлгүүрүүдэд хэрэгжинэ.



Урамшуулал



Бүтээгдэхүүнд хамаарах урамшууллын
нөхцөл, хугацааг мэдээлэх, урамшуулал
зарлах

- CU App-н урамшуулал /Зөвхөн CU APP ашиглан худалдан авалт хийх үед идэвхжинэ/
 - **N+1** – CU апп ашиглаж тодорхой хэмжээг худалдан авах үед нэг ширхгийг бэлэг болгох өгөх урамшуулал

- **Loyalty** – CU app-ын loyalty хэсэгт байршуулж хэрэглэгч нарт бонус онооны дагуу худалдаалах
- **Сугалаа** – Худалдан авалт хийх үедээ CU app-ын QR кодыг уншуулж бэлэгтэй сугалаанд оролцох
- POS-н урамшуулал
 - **Single item** – Тухайлсан бүтээгдэхүүн дээр оруулах хувь хямдралын урамшуулал
 - **N+1**- Бүтээгдэхүүнээс тодорхой тоогоор худалдан авах үед нэг ширхгийг хамт бэлэг болгох өгөх урамшуулал
 - **Free gift** – Худалдан авалт хийх үед хэрэглэгч нарт бэлэг болгон өгөх урамшуулал
 - **Combined** – Өөр нэг бүтээгдэхүүнтэй хамт худалдан авалт хийх үед урамшуулалтай болох багцийн хямдралтай урамшуулал

?

Би хэрхэн урамшуулал өгч буй бүтээгдэхүүнээ танай цахим сүлжээ болон ая тухтай дэлгүүрээр сурталчлуулах вэ?

-Бид хамгийн багадаа 30%-ийн хямдрал, урамшуулал өгч буй бүтээгдэхүүнийг өөрсдийн цахим хуудас болон салбар дэлгүүрээр зурагтай сурталчилгааны материал бэлдэж онцолж сурталчилдаг.

4. Баркодын

хүсэлт

Энэхүү цэсээр
дамжуулан та
одоо нийлүүлж
буй
бүтээгдэхүүний
баркодын
мэдээлэлд

өөрчлөлт оруулах хүсэлт илгээх боломжтой.



Баркодын өөрчлөлт



Нийлүүлж буй бүтээгдэхүүний баркодын
мэдээлэлд өөрчлөлт оруулах

5. Тасалдалт

Тухайн
бүтээгдэхүүний
нийлүүлэлтэд
түр хугацаанд
саатал гарах,
тасалдах нөхцөл
үүссэн
тохиолдолд энэ
цэсээр

дамжуулах мэдээлэл илгээх боломжтой.



Тасалдалт



Тухайн бүтээгдэхүүний нийлүүлэлтэд
тасалдал үүсэх тохиолдолд мэдээлэх, түр
хугацаанд нийлүүлэлтийг зогсоох

Тасалдлын мэдээ нь илгээсэн хугацаанаас хамаарч дараах
байдлаар ангилагдана:

- **Урьдчилсан тасалдал** – Тасалдал эхлэхээс хамгийн
багадаа 7 хоногийн өмнө илгээгдсэн мэдэгдэл

- **Гэнэтийн тасалдал** – Тасалдал эхлэхээс 7 хоногоос бага хугацааны өмнө илгээгдсэн мэдэгдэл

Хадгалалтын төрөл	Урьдчилсан тасалдлын хүсэлт	Гэнэтийн тасалдлын мэдэгдэл
Dry, Frozen	Тасалдал эхлэх огноогоор захиалга хаана.	Хүсэлт ирсэн өдрөөс календарийн 7 хоногийн дараа захиалга хаагдана.
Cold	Мэдэгдэлд заасан огноогоор захиалга хаана.	Мэдэгдэлд заасан огноогоор захиалга хаана.

6. Бүтээгдэхүүн хасах

Өөрийн нийлүүлж буй бүтээгдэхүүнийг CU ая тухтай дэлгүүрээс бүрэн хасаж, түүнд холбогдох нийлүүлэлтийг цуцлуулах хүсэлтийг бүртгүүлэхэд ашиглана.



Бүтээгдэхүүн хасах




CU ая тухтай дэлгүүрээс тодорхой бүтээгдэхүүнийг нийлүүлэлтээс хасах, цаашид нийлүүлэхгүй байх

7. Хамтын ажиллагаа




Энэ хуудас хөгжүүлэгдэж байна...

8. Захиалга



Энэ хуудас хөгжүүлэгдэж байна...

5. Захиалга



Энэ хуудас хөгжүүлэгдэж байна...

6. Гэрээ

Энэхүү цэсээр та өөрийн болон өөрийн төлөөлж буй байгууллагын ерөнхий мэдээллийг өөрчлөх ба мөн эрх бүхий ажилтныг томилох боломжтой

1. Байгууллагын профайл

Та өөрийн болон өөрийн төлөөлж буй байгууллагын ямарваа нэгэн мэдээллийг өөрчлөх үед Премиум Нэксус ХК-ийг төлөөлж тантай харилцаж буй Категори Менежерт шалгах мэдэгдэл ирнэ.



НӨАТ төлөгчийн мэдээлэл

✕

Та мэдээллийг хянаж батлана уу

Шинэ мэдээлэлХуучин мэдээлэл

2. Систем хэрэглэгч




Энэ хуудас хөгжүүлэгдэж байна...

7. Бүтээгдэхүүн


Энэхүү цэсээр та өөрийн болон өөрийн төлөөлж буй байгууллагын CU ая тухтай сүлжээ дэлгүүрт нийлүүлдэг бүх бүтээгдэхүүний дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой. Мөн тухайн бүтээгдэхүүнийг худалдан борлуулахад шаардагдах шинжилгээний бичгийн ерөнхий удирдлагыг хийнэ.

1. Мастер жагсаалт



Мастер жагсаалт хэсэг нь бүтээгдэхүүний ерөнхий мэдээллийг харахаас гадна Үйлдэл хэсэгт дарж тус бүтээгдэхүүнийг худалдан борлуулахад шаардагдах шинжилгээний бичгийн тус бүрчлэн нэмэх боломжтой.

2. Шинжилгээний бичиг



- **Бичиг нэмэх** – Олон бүтээгдэхүүн дээр ганц шинжилгээний бичиг байх тохиолдол байдаг ба та энэхүү тохиолдолд Шинжилгээний бичиг цонхоор нэвтэрч өөрийн нийлүүлж буй бүх бүтээгдэхүүнээс сонголт хийх боломжтой. Энэ нь Хамаарах бүтээгдэхүүнүүд хэсэг дээр харагдах болно.

8.Тусламж

Систем ашиглахтай холбоотой нэмэлт тусламжийн цэс

1. Үйлчилгээний нөхцөл

Энэхүү цэс нь Vendor Relationship System-ийг ашиглахтай холбоотой эрх, үүрэг, хариуцлага мэдээлэл ашиглалтын нөхцөл, нууцлалын бодлого болон системийн хэрэглээний ерөнхий журам зэргийг багтаасан болно.

Хэрэглэгч энэхүү системд нэвтэрч, үйлдэл хийхийн өмнө үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.



Үйлчилгээний
нөхцөл




Гарын авлага



2. Гарын авлага

Vendor Relationship System-ийн үйл ажиллагаанд хамаарах бүх төрлийн заавар, тайлбар, хэрэглээний алхамчилсан хөтөч, баримт бичгийн хэлбэртэй хэрэглээний материалыг энэ цэсээс үзэх боломжтой.

3. Санал, гомдол



Энэ хуудас хөгжүүлэгдэж байна...